



ХЭНТИЙ АЙМГИЙН  
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 05 өдөр

Дугаар 5/05

Мөрөн сум

Г Б.Мягмаржавыг "Номт Баян Мөрөн" Г  
орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот нийтлэг  
үйлчилгээний газрын захирлаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.23 дахь хэсэг, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Номт Баян Мөрөн" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот нийтлэг үйлчилгээний газрын захирлын албан тушаалд 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн (Б Мягмаржав)-ыг томилсугай.

2."Номт Баян Мөрөн" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот нийтлэг үйлчилгээний газрын захирал (Б.Мягмаржав)-ын үндсэн цалинг 3 000 000 (гурван сая) төгрөгөөр тогтоож, "Номт Баян Мөрөн" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот нийтлэг үйлчилгээний газрын үйл ажиллагааны орлогоос цалинжихыг зөвшөөрсүгэй.

3."Номт Баян Мөрөн" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот нийтлэг үйлчилгээний газрын захирал (Б.Мягмаржав)-тай эд хөрөнгө ашиглах гэрээ байгуулан хамтарч ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Намжилноров)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ХАТАНБААТАР